

**ХОРИГДОЛ, АЛБА ХААГЧДЫН ХООРОНД ҮҮСЭХ
ХАРИЛЦААНЫ ЗӨРЧЛИЙГ ОНОВЧТОЙ ШИЙДВЭРЛЭХ АРГА
ЗАМ**

**PRISONERS SERVED IN PRISON INSTITUTIONS,
OPTIMAL WAYS TO RESOLVE COMMUNICATION DISPUTES
BETWEEN OFFICERS**



Ө.Хүрэлшагай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 439 дүгээр хаалттай хорих ангийн төлөөлөгч, ахмад

Товч утга: Хорих байгууллагын үндсэн хүч болох алба хаагчдын мэргэжлийн ур чадвар болон харилцааны ур чадвар нь манай байгууллагын боловсон хүчний үндсэн гол шалгуур болж байна. Тиймээс дан ганц хоригдолтой харилцах биш нийгмийн харилцаанд жирийн иргэдтэй харилцахдаа ч ур чадварлаг, соёлтой, боловсон байх нь байгууллагын нэр хүндтэй холбоотой юм. Энэхүү илтгэлд алба хаагч болон хоригдлын хооронд үүсдэг харилцааны зөрчлийг оновчтой шийдвэрлэх арга замыг илэрхийлсэнд оршино.

Түлхүүр үгс: Харилцааны ур чадвар, хоригдол болон алба хаагчийн хоорондын харилцаа, харилцах мэдрэмж, хоригдлын харьцаа, алба хаагчийн харьцаа

Abstract: Professional skills and communication skills of the officers, which are the main strength of the prison organization, are the main criteria for the personnel of our organization. Therefore, being skilled, cultured, and refined in social relations, not only with prisoners, but also with ordinary citizens, is related to the reputation of the institution. In this report, the way to solve the conflict between the officer and the prisoner is expressed.

Key words: Communication skills, prisoner-officer relationship, empathy, prisoner relationship, officer relationship

Хорих ял эдэлж байгаа хүмүүс тодорхой төрлийн эрхээ хязгаарлуулсан ч үндсэн буюу заяагдмал эрх нь хязгаарлагдаагүй юм. Тэд нийгмийн харилцаанд чөлөөтэй орох эрхгүй хэдий ч хүн хоорондоо харилцах харилцаа нь тодорхой хэм хэмжээний хүрээнд явагдсаар байдаг.

Хоригдол алба хаагч хоорондын харилцаанд анхаарал татахуйц хэд хэдэн шинж тэмдэг сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон нь нийгэм цаг үеийн байдалтай шууд холбоотой. Тухайлбал алба хаагчийн шаардлага эсэргүүцэх, биелүүлэхгүй байх зэрэг зөрчлийн шинжтэй үйлдэл ихсэх хандлагатай байна. Хорих ял эдэлж байгаа хоригдлууд тухайн цаг үедээ тодорхой төрлийн хууль, эрх зүйн хэм хэмжээг даган мөрдөх зайлшгүй шаардлагатай боловч энэ төрлийн харилцаанд зөрчил үүсэх нь цөөнгүй байдаг. Энэ нь хувь хүний харилцааны ур чадвар, ухамсар болон цаг үеийн нөхцөл байдалтай шууд холбоотой байдаг.

Нийгэмд жирийн иргэд хоорондын харилцааны хэм хэмжээг нарийвчлан хууль, эрх зүйн хэм хэмжээнд зааж өгөх нь өрөөсгөл хэдий ч тусгай субъект энгийн иргэд хоорондын харилцааны хэм хэмжээг зохицуулан заасан байдаг хэд хэдэн жишээ байдаг. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улсын цагдаагийн алба хаагч жирийн иргэнтэй харилцаадаа ямар үг хэллэг хэрэглэх, яаж харьцах зэрэг харилцааны хэлбэрийг нарийн стандартад оруулан заасан байдаг. Энэ нь иргэдтэй харилцах харилцаанд ямар нэгэн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлсэн ач холбогдолтой. Үүний адилаар хоригдол болон алба хаагч хоорондын харилцааны хэлбэрийг нарийвчлан нэг стандартад оруулан мөрдүүлэх нь тэдний хооронд үүсэх зөрчлийг багасгах давуу талтай юм.

Хоригдол алба хаагч хоорондын харилцаа бүр зөрчилтэй байх нь байнга тохиолддог зүйл биш ч гэсэн харилцааны хувьд зөрчилдөх үйлдлийн хор хохирол нь ноцтой байх тохиолдол цөөнгүй байдаг. Цаашилбал хорих ангийн аюулгүй байдал, алба хаагчийн аюулгүй байдал, хоригдлын аюулгүй байдалтай ч шууд холбогдож болно. Тиймээс алба хаагчийн хоригдолтой харьцах харилцааг одоогийн хууль журамд зааснаас илүү нарийвчлан тодорхойлох шаардлага бий болж байна. Энэ нь хоригдол болон алба хаагчийн хоорондын харилцаанаас үүдэлтэй зөрчлийг бууруулах ихээхэн ач холбогдолтой юм.

Хоригдож буй этгээд бол нийгмээс тусгаарлагдсан байдаг ч хоригдож байгаа хоригдолтой хүн гэдэг нэр төрийг хүндэтгэж, хүnlэг энэрэнгүй харьцах ёстой . Хүnlэг бусаар хүний нэр төрийг доромжлон шийтгэхийг хориглосон арга хэмжээг заавал дагаж мөрдөх зүйл бөгөөд түүнийг зөрчсөн тохиолдлыг ямар ч нөхцөл байдлаар зөвтгөх аргагүй юм. Хууль бусаар авч хэрэглэсэн арга хэмжээг хэрцгий, хүnlэг бус харьцсантай адилтгаж үздэг. Тодорхой шаардлага хангаж, холбогдох сургалтад хамрагдсан, хоригдолтой яаж зөв харьцах, арга туршлагатай боловсон хүчинтэй байх нь хорих байгууллагын хүмүүнлэг тогтолцооны гол үндэс юм. Харамсалтай нь албан хаагчид болон хоригдогсдын хооронд зөрчилтэй төдий, үл хүндэтгэсэн шинжтэй харьцаа байсаар байна. Аюулгүй байдлыг хангах үүднээс хоригдолд алба хаагч хууль ёсны шаардлага тавих эрхтэй хэдий ч албан хаагч,

хоригдолгсын дунд сөрөг харилцаа гарсаар байна. Хоригдолтой харилцах жишиг хэм хэмжээг зөв зохистой дагаж мөрдөх нь харилсан хүндлэл бий болгох, тайван орчин бүрдүүлэх, эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Аливаа зөрчлийг цаг алдалгүй шийдвэрлэх ёстой, эс тэгвээс хязгаарлагдмал орчинд хурцадмал байдал эрт орой хэзээ нэгэн цагт асаж, магадгүй таны хувьд таагүй нөхцөл байдалд үр дагавар нь эмгэнэлтэй байж болно.

Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар гэдэг нь хоригдолтой харьцахдаа нэгэн зэрэг аюулгүй байдал, дэг журамд анхаарал хандуулж, хүнлэг энэрэнгүй, зохистой харьцах чадвар юм. Иймд удирдлага боловсон хүчинээ хоригдлын дунд зохих ёсоор биеэ авч явахад бэлэн байгаа гэдэг зохих түвшний бэлтгэлийг хангаж сурган дадлагажуулах зохион байгуулалтын арга хэмжээг авсан байх нь чухал. Албан хаагчид, хоригдлын хооронд харилцааны хэм хэмжээг нарийвчлан зааж зерэг харилцаа тогтоосноор харилцаанаас үүдэлтэй зөрчлийн эрсдэл буурах төдийгүй хяналт болон аюулгүй байдлыг улам хүчтэй болгоно. Ингэснээр албан хаагчид ч ажлаасаа ихээхэн таашаал авах боломжтой болно.

Боловсон хүчин хүрэлцэхгүй, хангалтгүй байгаа газарт аюулгүй байдал, байгууллагын хэвийн ажиллагааг хангахын тулд ихээхэн хэмжээгээр илүү цагаар ажиллах шаардлага гардаг. Ийм байдал нь албан хаагчдын стрессийг хэт өндөрсгөж, тэдний хүчийг барж, хоригдолтой харилцах харилцаанд зөрчил үүсэх үндэс болдог. Энэ нь хорих, цагдан хорих аль ч газарт байдаг хүндрэлийг улам л ихэсгэж байна.

Хорих байгууллагын ажилтан хоригдолтой харьцах хууль эрх зүйн хэм хэмжээ нь: Хорих байгууллагын албан хаагчдын зүгээс ялтантай хүнлэг, энэрэнгүй, хууль ёсны эрх, эрх чөлөөг хүндэтгэж эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн хүрээнд харьцана.

Хорих байгууллагын албан хаагч ялтныг ял шийтгэл, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол зэргээр ялгavarлан харьцахыг хориглоно.

Хоригдол албан хаагчтай харьцахдаа түүний албан тушаал, эсвэл цолыг хэлж, өөрийн овог нэр, шийтгүүлсэн эрүүгийн хуулийн зүйл, заалтыг танилцуулж, хүсэл гомдоло товч тодорхой илэрхийлнэ.³⁴ Гэж тус тус заасан байхад хоригдлууд хоорондоо “энгийн иргэдийн адилаар бие биенээ “Та” гэж харьцана” гэж тусгажээ. Дээрх харилцааны хэм хэмжээ зөрчигдөх тохиолдол хүлээлгэх хариуцлага нь тухайн хоригдлын эрх зүйн байдлыг дордуулж байdag ч хоригдлууд мэдсээр байж ямар нэгэн төрлийн харилцааны зөрчил гаргах тохиолдол бүртгэгдсээр байна.

Хоригдол хорих ял эдлэх хугацаандаа “хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах”³⁵ эрхтэй гэж заасан бөгөөд

³⁴ Хорих ангийн дотоод журмын 7 дугаар зүйл

³⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210.1.9.

хоригдол алба хаагч хоорондын харилцаанд зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Гэвч хоригдлын зүгээс элтэд дээрх эрхээ тайлбарлан, тоочих тохиолдол бага байдаг.

Хоригдол нь “Хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтан, бусад хоригдол болон хорих байгууллагад байгаа бусад хүнтэй хүндэтгэлтэй харьцах”³⁶ үүрэгтэй гэж заасан. Хоригдол нь дээрх эрхийг эдлэхийн дагуу мөн тодорхой төрлийн тухайлбал алба хаагч болон бусад хоригдолтой хүндэтгэлтэй хандах үүрэгтэй юм. Энэхүү харилцааны хэлбэрийг зохицуулсан хууль журмын хэм хэмжээний заалт багагүй зөрчигддөг заалт юм. Мөн алба хаагч хоригдолтой харилцаахдаа дараах хэлбэрийн зөрчил гаргахыг хориглосон байдаг. хоригдолтой хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах.³⁷

Хорих байгууллагад хорих ял эдэлж байгаа хоригдол алба хаагч хоорондын харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, хорих ангийн дотоод журамд зааснаас гадна хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэмд хоригдолтой дараах хэлбэрээр харьцах талаар тусгасан байна.

Харилцах процесс нь хүмүүс хоорондоо харилцан үйлчлэлцэх, мэдээлэл дамжуулан солилцох, найз нөхдийн хувьд хүмүүс бие биедээ хандах, харилцан бие биедээ нөлөөлөх, хэн хэнийхээ сэтгэл санааны байдлыг мэдэрч хуваалцах, харилцан ойлголцох зэрэг олон асуудлыг нэгэн зэрэг илэрхийлж байдаг” гэж тодорхойлсны зэрэгцээ шинжлэх ухааны үүднээс харилцааг олон янзаар тодорхойлсон байдаг.³⁸

- Харилцаа нь амьд ахуйн үндсэн нөхцөл юм.
- Харилцаа бол хүмүүсийн дотоод сэтгэлийн хэрэгцээ юм.
- Харилцаа нь хүмүүсийн сэтгэл хөдөлгөөний илэрхийлэл мөн.
- Харилцаан хүмүүсийн хоорондын энергийн харилцан солилцоо мөн.
- Харилцаа нь харилцан нөлөөлөл юм.
- Харилцаа бол харилцагч хүнээ таних, судлах арга болдог.
- Харилцаа нь бие хүнийг төлөвшүүлэх хэрэглүүр мөн.
- Харилцаа бол соёл юм.

Харилцааны бүтэц нь хэлхээ холбоо тогтоох буюу харилцагчдын хооронд мэдээлэл солилцох үйл явцыг багтаасан харилцааны явцуу утга, харилцагчдын хооронд мэдээлэл, үзэл санаагаа солилцохын зэрэгцээ үйлдэл солилцох, харилцан үйлчлэх, харилцаанд оролцогчид бие биээ хүндлэн хүлээн авахдаа харилцан ойлголцлыг төрүүлэх мэдрэхүйн хэсгүүдээс бүрдэнэ.

“Харилцааны үед уур амьсгалыг бүхэлд нь тодорхойлж байдаг үндсэн 3 чиг үүрэг хэрэгждэг”³⁹

³⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 211.1.8.

³⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 251.1.5.

³⁸ Оросын сэтгэл зүйч Д.Париган

³⁹ Оросын нэрт сэтгэл судлаач Б.Ф.Ломов

- Мэдээллийн хэлхээ холбоо
- Зохицуулалтын хэлхээ холбоо
- Сэтгэл хөдлөл мэдрэмжийн хэлхээ холбоо

Харилцааны ур чадвар нь: Хүмүүс хоорондын харилцааны ур чадвар гэдэг нь ажил хөдөлмөрийн ур дүнг шууд тодорхойлж чадах хүмүүстэй харилцах эв дүй, ур ухаан, арга барил, дадлын цогц шинж юм. Хүмүүсийн нас, боловсрол, соёл, сэтгэцийн хөгжлийн янз бүрийн төвшин, амьдралын болон ажил мэргэжлийн туршлага тэдний харилцааны ур чадварт хүчтэй нөлөө үзүүлдэг. Харилцааны ур чадварыг ерөнхий ба тусгай гэж 2 хуваадаг.

Тусгай чадварууд хүний харилцааны ерөнхий чадваруудад суурилан мэргэжлийн болон мэргэшсэн үйлдэл, үйл ажиллагааны явцад хөгждөг.

Хоригдол харьцааны зөрчил гаргахад нөлөөлдөг хүчин зүйлд:

1. Сэтгэл түгших: Энэ нь хэр зэрэг гарч байгаа нь хорих нөхцөл байдал, тухайн субъектийн хувийн шинж чанараас хамаарна. Тэд үл мэдэгдэх зүйлтэй тулгардаг.

2. Нууцлал алдагдах: Энэ нь бусад хоригдлуутдай хүчээр зэрэгцэн оршихоос үүсдэг.

Тэд өөрсдийгөө төвлөрүүлэх цаг зав багатай эсвэл огт байдаггүй.

Хүрээлэн буй орчин хүчирхийлэлтэй байгаа тохиолдолд энэ нь улам дорддог таны аюулгүй байдал эрсдэлд орно.

3. Өөрийгөө үнэлэх чадвар багатай: Энэ нь хүний хүлээлтийг биелүүлэхгүй байх эсвэл өөрийнхөө дүр төрхийг хуурч мэхлэх, шоронд хоригдох явдал юм.

Гэсэн хэдий ч, өөрийгөө үнэлэх байдалд сөргөөр нөлөөлдөггүй бусад олон хүмүүс байдаг. Учир нь тэд эрүүгийн амьдралаар амьдрахдаа сэтгэл хангалиун байдаг.

4. Өөрийнхөө амьдралыг хянах чадваргүй байдал: Энэ нь хувийн, гэр бүл, нийгмийн шийдвэр гаргах тодорхой чадваргүй байдлаас болж үүсдэг; Хамгийн хязгаарлагдмал зүйл бол гадны үйл явдлын хувьслын дотоод хяналт юм. Энэ байдал нь бухимдлыг төрүүлдэг. Хорих ял эдэлж байгаа орчин нь хоригдлуудад маш ихээр нөлөөлдөг.

Дүгнэлт

Жирийн иргэдийн хооронд үүсдэг харилцаанд зөрчилдөөнд байдал үүсэх нь цөөнгүй хэдий ч үүсэх хор хөнөөл нь бага байдаг бол нийгмээс тусгаарлагдсан хоригдлуудын хооронд үүсэх харилцааны зөрчил түүнчлэн алба хаагч хоригдлын хооронд үүссэн харилцааны зөрчлөөс үүсэх хор хөнөөл нь нэлээдгүй хурцадмал хэлбэртэй байдаг. Тиймээс хоригдол болон алба хаагч хоорондын харилцааны зөрчлөөс үүсэх хор хөнөөлийг багасгах зорилгоор харилцаанд баримтлах хууль эрх зүйн хэм хэмжээг нарийвчлан боловсруулах нь чухал ач холбогдолтой юм

Санал

1.Хорих ял эдэлж байгаа хоригдол алба хаагч хоорондын харилцааны зөрчлийг зохицуулсан хууль журмын хэм хэмжээг нарийвчлан зааж боловсронгуй болгох;

2.Хоригдол алба хаагчийн хоорондын харилцааны талаарх сургалтын хөтөлбөрийг боловсруулж алба хаагчдын сургалтад нэвтрүүлэх.

Эх сурвалжийн жагсаалт

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль УБ хот /2017 он./
2. Хорих ангийн дотоод журам /2017 он 07 дугаар сарын 04-ний А/183 тушаал/
3. Оросын сэтгэл зүйч Д.Париган
4. Оросын нэрт сэтгэл судлаач Б.Ф.Ломов /проблемы и стратегия психологического исследования/

---o0o---